



# ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

---

2020 оны 33 болон 34 дэх долоо хоног

---

## ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

2020 оны 8-р сарын 6-аас 8-р сарын 19-ний байдлаар

Ковид-19 дэлхий нийтээр хурдтай тархаж, цар тахлын түвшинд хүрээд буй өнөөгийн нөхцөлд глобал эдийн засаг, санхүүгийн зах зээлд томоохон өөрчлөлтүүд гарч байна. Эдгээр өөрчлөлтүүд болон эдийн засгийг тогтворжуулахад улс орнуудын авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээний талаар тухай бүр мэдээлж байх зорилгоор Монголбанкнаас долоо хоног тутам бэлтгэн хүргэж буй гадаад орчны тойм мэдээллийн 21 дэх дугаарыг хүргэж байна.

### 1 ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨ

- **ОУВС** “Гадаад секторын тайлан”-гийн шинэ дугаарыг нийтэллээ. Дэлхийн эдийн засгийн 90%-ийг бүрдүүлдэг 30 улсын төлбөрийн тэнцэл, гадаад позицийг эмхэтгэн жилд 1 удаа нийтэлдэг тус тайланд дурдсанаар **2019 оны байдлаар** дэлхийн нийт урсгал тэнцэл дэлхийн ДНБ-ий **2.9 хувьтай тэнцэж байгаа нь** өмнөх оноос 0.2 нэгж хувиар багассан үзүүлэлт болов. ОУВС-гийн тооцооллоор дэлхийн улс орнуудын урсгал тэнцлийн алдагдал болон ашгийн 40 орчим хувь нь зохистой түвшнээс хазайсан буюу хэт алдагдал эсвэл хэт илүүдэлтэй байна. 2020 онд цар тахлын улмаас дэлхийн худалдааны эргэлт буурч, түүхий эдийн үнэ унан, гадаад санхүүжилтийн боломж хязгаарлагдмал болсон тул урсгал тэнцэл дэлхийн ДНБ-ий 0.3-тэй тэнцэх хэмжээгээр агших хүлээлтэй байна. Гадаад орчны тодорхой бус байдал нэмэгдсэн үед урсгал тэнцлийн алдагдал зохистой түвшнээс өндөр орнуудад хүндрэл үүсгэж болзошгүйг ОУВС-гаас анхааруулж, төсвийн сахилга батыг хангаж өрийн тогтвортой байдлыг хангах, гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх, экспортыг өрсөлдөх чадвартай болгох бүтцийн бодлогуудыг авч хэрэгжүүлэхийг зөвлөж байна.
- **Deutsche Bank** 8-р сарын 5-нд нийтэлсэн “Дэлхийн эдийн засгийн төлөв” тайландаа **дэлхийн эдийн засгийн өсөлтийн төсөөллийг өмнөх улирлын төсөөллөөс 0.5-1.0 нэгж хувиар сайжруулж, 2020 онд 4.5 хувиар агших** төсөөлөл боловсруулжээ. Голлох эдийн засгуудыг авч үзвэл АНУ-ын эдийн засаг энэ онд 5.2 хувиар, Евро бүсийн эдийн засаг 8.6 хувиар агших бол БНХАУ-ын эдийн засаг 1.6 хувиар өсөхөөр төсөөлсөн байна. Ази болон Европын зарим орнуудад цар тахлын нөхцөл байдал дээрдэж, төсвийн бодлого эдийн засагт дэмжлэг болж байгаа нь төсөөллийг сайжруулахад нөлөөлөв.
- **Цар тахлын улмаас Евро бүсийн ажил эрхлэлт оны эхний хагаст 4.9 саяар буурчээ.** Энэ нь өмнөх хямралаас хойш 12 саяар нэмэгдсэн ажлын байрны 40 гаруй хувийг алдсан гэсэн үг юм.
- **Японы эдийн засаг 2020 оны 2-р улиралд өмнөх улирлаас 7.8 хувиар буюу жилд шилжүүлбэл 27.8 хувиар агшжээ.** Үүнд цар тахлын улмаас хувийн хэрэглээ, хөрөнгө оруулалт буурч, гадаад эрэлт огцом буурснаар АНУ, Европ руу гаргах экспорт багассан нь голлон нөлөөлөв.



Тухайлбал, хувийн хэрэглээ өмнөх улирлаас жилд шилжүүлсэн дүнгээр 28.9 хувиар, бизнесийн хөрөнгө оруулалт 5.8 хувиар тус тус буурсан бол цэвэр экспорт эдийн засгийн өсөлтөд 3 нэгж хувийн сөрөг нөлөө үзүүлжээ. Японы эдийн засаг цар тахлын өмнөх түвшинд очиход 4 жилийн хугацаа шаардагдана гэж үзэж байна.

- **БНХАУ-ын Засаг захиргааны онцгой бүс Хонконгийн эдийн засаг 2020 оны 1-р улиралд өмнөх оны мөн үеэс 9.1 хувиар, 2-р улиралд 9.0 хувиар агшжээ.** Хонг Конгийн захиргаа хямралын эсрэг томоохон багц арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа ч оны эхний хагасын гүйцэтгэл төсөөллөөс доогуур байсан тул ЗГ-аас энэ оны эдийн засгийн өсөлт -6-аас -8 хувийн хооронд байхаар төсөөллөө бууруулав.
- **АНУ-ын Холбооны нөөцийн банк энэ оны 9-р сард Инфляцын шинэ стратеги нэвтрүүлэх хүлээлттэй байна.** ХНБ бүрэн ажил эрхлэлтийг хангах, үнийн түвшнийг тогтвортой байлгах төв банкны үндсэн зорилтдоо хэрхэн хүрэх стратегидаа анх удаа өөрчлөлт оруулж Конгрессоор батлуулах юм. Шинэ стратегийн дагуу ХНБ инфляцыг богино хугацаанд 2 хувиас давахыг хүлээн зөвшөөрөөд зогсохгүй, олон жил зорилтот түвшнээс доогуур хадгалагдаж буй инфляцыг нэмэгдүүлэх чиглэлд бодлогыг хэрэгжүүлнэ гэж зах зээл хүлээж байна. Хэрэгслийн хувьд ХНБ-ий хүү тэг түвшинд ойртсон тохиолдолд хасах хүүний бодлого хэрэгжүүлэхгүй, харин одоогийн бонд худалдан авах, хүүний ирээдүйн хандлагын талаар олон нийтэд мэдээлэх хэрэгслийг ашиглана гэж шинжээчид үзэж байна.

- **Английн Төв банкны Мөнгөний бодлогын хороо 8-р сарын 4-нд хуралдан, бодлогын хүүг 0.1 хувьд хэвээр хадгалах шийдвэр гаргалаа.** Их Британийн эдийн засаг 2-р улиралд өмнөх улирлаас 20.4 хувиар буюу жилд шилжүүлбэл 60 хувиар буурчээ. Харин төлбөр тооцооны өндөр давтамжтай тоон мэдээллээс харахад 7-р сард өрхийн хэрэглээ оны эхнээс 10 орчим хувиар бага байгааг илтгэж байгаа бөгөөд цаашид хувийн хэрэглээ сэргэж, бизнесийн хөрөнгө оруулалт алгуур нэмэгдэн, ажилгүйдэл буурч, ажилгүйдлийн түвшин оны эцэст 7.5 хувьд хүрэх хүлээлттэй байна. ДНБ 2021 оны эцэст цар тахлын өмнөх түвшинд хүрэх хүлээлттэй бөгөөд инфляц ирэх 2 жилийн хугацаанд зорилтот 2 хувийн түвшинд очих төлөвтэй байна.

#### *Эх сурвалж:*

1. IMF, [External Sector Report](#)
2. Deutsche Bank, [World economic outlook: the patient's progress](#)
3. Bloomberg, [Euro Area Sheds Almost Half of Jobs Created Since Last Recession](#)
4. Hong Kong Economy, [Latest Developments](#)
5. Bloomberg, [Fed Close to Making Its New Inflation Strategy Official](#)
6. Bank of England, [Bank Rate maintained at 0.1% - August 2020](#)

## 2 БНХАУ-ЫН ЭДИЙН ЗАСАГТ ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТҮҮД

- 8 дугаар сарын 14-ны өдөр **БНХАУ-ын Үндэсний Статистикийн Хорооноос** эдийн засгийн голлох үзүүлэлтүүдийн 7 дугаар сарын гүйцэтгэлийг зарлалаа. Үйлдвэрлэл, нийлүүлэлт сэргэж, зах зээлийн эрэлт хэрэгцээ аажмаар нэмэгдэж, ажил эрхлэлт болон үнэ тогтвортой байж, зах зээлийн итгэл нэмэгдсэн байна. Тус тайланд БНХАУ-ын эдийн засгийн салбаруудын сэргэлт жигд бус байгаа хэдий ч ерөнхийд нь харвал тогтвортой сэргэж байна гэж дүгнэсэн байна.
- БНХАУ-ын Хэрэглээний үнийн өсөлт тогтвортой байж, аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэгчийн үнэ буурсан байна. 7 дугаар сард хэрэглээний үнэ өмнөх оны мөн үеэс 2.7 хувиар, өмнөх сараас 0.2 хувиар өссөн байна. 2020 оны эхний 7 сарын байдлаар хэрэглээний үнэ өмнөх оны мөн үеэс 3.7 хувиар өсч, тогтвортой байна. Хоол хүнс, тамхи, согтууруулах ундааны үнэ 7 дугаар сард өмнөх оны мөн үеэс 10.2 хувиар, боловсрол, соёл, амралт 0.3 хувиар, эрүүл мэндийн үйлчилгээ 1.6 хувиар, бусад үйлчилгээ 5.1 хувиар, шинэ ногоо 7.9 хувиар, гахайн махны үнэ хамгийн ихээр буюу 85.7 хувиар тус тус өссөн бол орон сууцны үнэ 0.7 хувиар, тээвэр, харилцаа холбоо 4.4 хувиар, шинэ жимсний үнэ 27.7 хувиар тус тус буурсан байна. Харин аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэгчийн үнэ 7 дугаар сард өмнөх оны мөн үеэс 2.4 хувиар буурсан бол эхний 7 сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 2.7 хувиар буурсан байна.
- 7 дугаар сард үйлчилгээний үйлдвэрлэлийн индекс өмнөх оны мөн үеэс 3.5 хувиар, өмнөх сараас 1.2 хувир өсч, эхний 7 сард өмнөх оны эхний 7 сараас 4.7 хувиар буурсан байна. Гол салбаруудаар нь авч үзвэл: мэдээлэл холбоо, програм хангамж, мэдээллийн технологийн үйлчилгээний үйлдвэрлэлийн индекс өмнөх оны мөн үеэс 13.7 хувиар, санхүүгийн зуучлал, үл хөдлөх хөрөнгө болон бусад үйлчилгээний үйлдвэрлэлийн индекс өмнөх оны мөн үеэс 10.4 хувь, 7.8 хувь болон 3.3 хувиар тус тус өсч, өмнөх сараас 2.9, 3.9, 2.3 нэгж хувиар тус тус өссөн байна. Шуудангийн үйлчилгээ, шуурхай хүргэлт, байр, хоолны газар, харилцаа холбоо, үнэт цаасны бизнесийн идэвхжлийн индекс 6-р сартай харьцуулахад өссөн бөгөөд нийт бизнесийн үйл ажиллагааны индекс бага зэрэг өссөн байна. Соёл, спорт, үзвэрийн үйлчилгээ болон оршин суугчдын үйлчилгээний бизнесийн индекс тус бүр өмнөх оны мөн үеэс 51.9 хувь, 51.1 хувиар, өмнөх сараас 6.1 нэгж хувь, 1.9 нэгж хувиар тус тус өссөн байна. Мэдээлэл холбоо, програм хангамж, мэдээллийн технологийн үйлчилгээний бизнесийн орлого өмнөх оны мөн үеэс 9.7 хувиар өсчээ.
- Өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний борлуулалтын нийт хэмжээ 3,220.3 тэрбум юаньд хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 1.1 хувиар, 6-р сартай харьцуулахад 0.7 пунктээр буурч, сарын өсөлт 0.85 хувь байлаа. Үүнд эдийн засгийн тодорхой бус байдлаас үүдэн өрхүүдийн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний зарцуулалт ихээр буураад байгаа нь голлон нөлөөлж байна. Бүс нутгаар нь хуваавал, 7 дугаар сард хот суурин газрын жижиглэнгийн худалдаа өнгөрсөн оны мөн үеэс 1.1 хувиар буурч 2,802.5 тэрбум юаньд хүрсэн бол хөдөө орон нутагт 1.3 хувиар буурч 417.8 тэрбум юаньд хүрчээ. Хэрэглээний хэв маягаар нь ангилж үзвэл хоолны газрын орлого өнгөрсөн оны мөн үеэс 11.0 хувиар буурч 328.2 тэрбум юаньд хүрсэн байна. Харин энэ онд бууралттай байсан бараа бүтээгдэхүүний жижиглэнгийн



худалдаа анх удаа тэлэн 0.2 хувиар өсч, 2,892.0 тэрбум юаньд хүрсэн бөгөөд өдөр тутмын үндсэн хэрэглээний барааны худалдаа хурдацтай өсчээ. Онлайн жижиглэнгийн худалдаа 15.7 хувиар өссөн дүнтэй байна.

- Нийт хөрөнгө оруулалтын хэмжээ буурч, өндөр технологийн аж үйлдвэр, нийгмийн салбарын хөрөнгө оруулалт хурдацтай нэмэгдэв.
- Эхний 7 сарын байдлаар хот, суурин газарт шинээр нэмэгдсэн ажилчдын тоо өнгөрсөн оны мөн үеэс 1.96 саяар буурч 6.71 саяд хүрчээ. Судалгаанд голлох 31 томоохон хот, суурин газрыг хамруулсан бөгөөд ажилгүйдлийн түвшин өмнөх сарын түвшинд буюу 5.8 хувь байна. Үүнээс 25-59 насны иргэдийн ажилгүйдлийн түвшин 5.0 хувь буюу өмнөх сараас 0.2 нэгж хувиар буурсан дүнтэй байгаа бол залуучуудын ажилгүйдлийн түвшин бага зэрэг өссөн байна. Аж ахуйн нэгжүүдийн долоо хоногийн дундаж ажлын цаг 46.8 цаг буюу 6-р сартай ижил байв.
- Бээжин хотод 8 дугаар сарын эхээр үерийн улмаас цэцэрлэгт хүрээлэнгүүдийг хааж, шаардлагагүй тохиолдолд гадагш гарахгүй байхыг зөвлөж, DaXing нисэх онгоцны буудал бүх нислэгээ цуцалжээ. Хотын дарга 2012 онд 80 хүний аминд хүрсэн үерийн гамшиг дахин давтагдах эрсдэлээс сэргийлж буйгаа илэрхийлжээ. 6 болон 7 дугаар саруудад БНХАУ-ын өмнөд болон төвийн нутгуудаар олон өдөр тасралтгүй бороо орж, үер буусны үр дүнд 158 хүн ор сураггүй алга болж, 3.7 сая хүнийг нүүлгэж шилжүүлж, 144 тэрбум юанийг хохирол барагдуулахад зарцуулснаас гадна их хэмжээний тариалангийн талбай үгүй болсон байна. Энэхүү цаг агаарын нөхцөл байдлаас үүдэн хүнсний үнэ өмнөх оны мөн үеэс 13 хувиар өсөөд байгаа нь КОВИД-19 цар тахлаас болж хүндрэлд ороод байгаа эдийн засгийн сэргэлтэд сөргөөр нөлөөлж байна. Шанхай хотод

хүнсний захуудад ногооны үнэ 7 дугаар сард өмнөх сартай харьцуулахад 10-20 хувиар өссөн байна.

- БНХАУ-ын эдийн засгийн төлөвлөгч байгууллага болох Үндэсний Хөгжил Шинэчлэлийн Хорооноос (NDRC) 7 дугаар сард 5.5 тэрбум долларын хөрөнгө оруулалттай 11 үндсэн хөрөнгө оруулалтын төслийг баталсныг мэдэгдлээ.
- БНХАУ-ын Ардын банк 4 сар дараалан дунд хугацаатай зээлийн (MLF) эргэн төлөгдөх хугацааг сунгалаа. БНХАУ-ын Ардын банкнаас дунд хугацаат зээлийн сангаас санхүүгийн байгууллагуудад олгож буй 1 жилийн хугацаатай 700 тэрбум юань буюу 100 орчим сая ам.долларын зээлийн хүүг өмнөх хэлцлүүдийн адил 2.95%-д хэвээр хадгалснаа мэдэгдлээ. Шинжээчид БНХАУ-ын зээлийн хүүгийн үндсэн түвшний хязгаарт (LPR) өөрчлөлт гарахгүй гэсэн хүлээлттэй байна.
- **БНХАУ-ын аж үйлдвэрийн Caixin PMI индекс 6-р сард 51.2 хүрсэн бол 7-р сард 52.8 буюу 2011 оны эхний үеэс өндөр түвшинд хүрч нэмэгдэв.** Үүнд гадаад эрэлт нэмэгдэн, шинэ захиалгын тооны өсөлт хадгалагдсан нь нөлөөлөв. “Дотоодын эдийн засгийн идэвхжил сайжирч байгаа хэдий ч гадаад эрэлт болон ажил эрхлэлт сул байгааг онцгойлон анхаарах хэрэгтэй” гэж ‘The Caixin Global’-аас анхаарууллаа. Түүнчлэн “The Caixin Global” -ийн судалгаагаар экспортын эрэлт 7 дахь сардаа дараалан буурсан дүнтэй байна.
- **БНХАУ-ын аж үйлдвэрийн албан ёсны PMI индекс 6-р сард 50.9 хүрсэн бол 7-р сард хүлээлтийг давж, 51.1-т хүрч нэмэгдэв.** Эрэлт нэмэгдсэн нь үүнд голлон нөлөөлсөн ба ажил эрхлэлтийн бүрэлдэхүүн индекс 50-аас доогуур түвшинд хадгалагдсан нь компаниуд ажилчдын төвлөрлийг





бууруулсан хэвээр байгааг илэрхийлж байна.

- **БНХАУ-ын гангийн үйлдвэрлэлийн PMI 5-р сард 50.9, 6-р сард 49.3 байсан бол 7-р сард 49.2 болж, тус салбарын үйлдвэрлэл агшлаа.** Гангийн эрэлт саарч, үерийн улмаас тээвэрлэлтэд саатал гарсан тул үйлдвэрлэл ийнхүү удааширчээ. БНХАУ-ын ган, төмрийн ассиоциацийн мэдээлснээр гангийн өдрийн дундаж үйлдвэрлэл 7-р сард өмнөх сараас 1.09 хувиар буурсан байна. Харин **БНХАУ 7-р сард экспортоос давсан хэмжээгээр ган импортлосон нь 2009 оноос хойших хамгийн өндөр дүн байв.** Өнгөрсөн сард ажиглагдсан энэхүү шилжилт нь дотоодын үйлдвэрлэл бага байгаагийн зэрэгцээ БНХАУ-ын эдийн засагт түүхий эдийн эрэлт өндөр байгааг илэрхийлж байна гэж Рио Тинто Групп онцлов.
- БНХАУ-ын Ардын Банкны мэдээлснээр **үл хөдлөх хөрөнгийн зээл 6 дугаар сарын сүүлээр өмнөх оны мөн үеэс 13.3 хувиар өсч 47.40 их наяд юаньд (6.8 их наяд ам.доллар) хүрсэн байна.** ХАБ-аас мэдэгдсэнээр ипотекийн зээл мөн хугацаанд 15.7 хувиар өсч 32.36 их наяд юаньд хүрсэн дүнтэй байна.
- **2020 оны эхний 6 сарын байдлаар Зүүн-Өмнөд Ази БНХАУ-ын худалдааны гол түнш болоод байна.** Тодруулбал, 2020 оны эхний хагас жилд БНХАУ-ын Евро бүстэй хийх худалдаа 5 хувиар, АНУ-тай хийх худалдаа 10 хувиар тус тус буурсан бол Зүүн-Өмнөд Азитай хийх худалдаа нэмэгджээ. Мөн БНХАУ-ын үйлдвэрлэгчид зардлаа танах, АНУ-ын татвараас зайлсхийхийн тулд Зүүн-Өмнөд Ази руу зарим бүтээгдэхүүн үйлдвэрлэлээ шилжүүлсэн байна. Сингапур улс өндөр өртөгтэй

бүтээгдэхүүний үндсэн нийлүүлэгч болоод байгаа бол Вьетнам улс бага цалингаар үйлдвэрлэл хийхэд тустай байгаа аж. Ингэснээр БНХАУ компаниудаас Зүүн-Өмнөд Азид оруулах ГШХО ч нэмэгдээд байна.

- АНУ болон БНХАУ-ын хоорондын улс төрийн харьцаа хурцадмал байгаа хэдий ч **АНУ-ын компаниудын БНХАУ руу оруулсан гадаад шууд хөрөнгө оруулалтын хэмжээ 2020 оны эхний хагаст өмнөх оны мөн үеэс 6 хувиар өссөн дүнтэй байна.** Харин БНХАУ-ын нийт ГШХО мөн хугацаанд 1.3 хувиар буурчээ. АНУ-ын ЗГ-аас БНХАУ улсад Хонг Конгийн үйл ажиллагаатай холбоотойгоор хориг тавиад байгаа нь цаашид АНУ-ын компаниудын хөрөнгө оруулалт буурах эрсдэлийг үүсгэж байна. Үүний эсрэг БНХАУ-ын ЗГ-аас хөрөнгө оруулагчдыг дэмжиж, таатай нөхцөлийг бүрдүүлж зарим хязгаарлалтуудыг зөөллөх арга хэмжээг авч эхэлжээ. Мөн Япон Улсын компаниуд БНХАУ-аас хөрөнгөө татах магадлал өндөр болоод байгааг БНХАУ-ын ЗГ онцгойлон анхаарч байна. Учир нь КОВИД-19 цар тахлын нөлөөгөөр БНХАУ-аас ирэх бараа ихээр багассан тул, Японы компаниуд өөрсдийн нийлүүлэлтийн сүлжээг илүү тогтвортой болгохын тулд үйлдвэрлэлээ Япон эсвэл өөр улсууд руу (ихэвчлэн Зүүн-Өмнөд Азийн орнууд) шилжүүлж, компаниа нүүлгэн шилжүүлэх алхмыг хийж эхэлсэн байна.

#### **Эх сурвалж:**

1. National Bureau of Statistics of China, [National Economy Sustained a Steady Recovery in July](#)
2. Financial Times, [Beijing on flood alert as rains hamper China's economic recovery](#)
3. Continuum Economics, [China's Regional Growth and "Domestic Cycle"-Centric Development Strategy](#)
4. FT, [China retail sales fall for seventh straight month](#)



5. Reuters, [China approves 11 fixed-asset investment projects worth \\$5.5 billion in July](#)

6. Reuters, [China central bank injects 700 billion yuan of MLF loans, rates steady for fourth month](#)

### 3 МОНГОЛБАНК, ЗАСГИЙН ГАЗРААС АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ АРГА ХЭМЖЭЭ

“КОВИД-19 цар тахлын үед санхүү, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, эрсдэлээс урьдчилсан сэргийлэх, төрийн үйлчилгээнд цахим шилжилт хийх арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2020 оны 32 дугаар тогтоолоор чиглэл болгосон банкны зээлийн хүү болон зээлийн эх үүсвэрийн зардлыг бууруулах стратегийн батлах төслийг УИХ-ын гишүүд УИХ-ын даргад өргөн барилаа.

Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн дагуу Улсын Их Хурлаас цар тахлын нөлөөллөөр хумигдаад байгаа санхүүгийн хүртээмж, зуучлалыг зээлийн хүү өндөр байгаагийн улмаас зогсонги байдалд хүргэхээс сэргийлэх үүднээс түүнд нөлөөлж байгаа хүчин зүйл, шалтгаант холбоог тодорхойлсон судалгааны үр дүнд тулгуурлаж зээлийн хүүг бууруулах стратеги хэрэгжүүлэх нь нэн тэргүүний ажил болоод байна. Сүүлийн жилд банкны салбарын зээлийн хүү 4 нэгж хувиар тогтвортой буурч 2020 оны 6 дугаар сарын эцсийн байдлаар жигнэсэн дундаж хүү жилийн 16.3 хувь болсон. Гэсэн ч тулгамдсан асуудлын нэг хэвээр байгаа тул эдийн засгийг төрөлжүүлэх, бизнесийн хөрөнгө оруулалт хийх, ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжихүйц түвшинд зээлийн хүүг дорвитой бууруулах шаардлагатай байна.

Тиймээс зээлийн хүүг бууруулахад санхүү, эдийн засгийн бодлого болоод хууль эрх зүйн шинэчлэлийн хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлж, үр дүнтэй хэрэгжүүлснээр Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын зорилт хангагдах суурь нөхцөл бүрдэх болно.

Зах зээлийн зарчмаар тогтож байгаа зээлийн хүүнд зөвхөн банк, санхүүгийн байгууллагуудын шийдвэрээс үл хамаарах суурь инфляц, улсын дотоодын нийт хуримтлалын хэмжээ, гадаад валютын нөөц, эрсдэл, санхүүгийн салбарын хөгжил, олон улсын захтай холбогдсон байдал, хууль эрх зүйн орчин, макро орчны тогтвортой байдал, банкны харилцагчийн зан төлөв зэрэг олон хүчин зүйл нөлөөлдөг. Судалгаагаар банкны зээлийн хүүний бүтцийг үзвэл татан төвлөрүүлсэн эх үүсвэрийн зардал 60 орчим хувь буюу зээлийн хүүнд эзлэх хувь нь 9.8 нэгж хувь, үйл ажиллагааны зардал 17 хувь, зээлийн хүүний 2.8 нэгж хувь, зээлийн эрсдэлийн зардал 11 хувь, зээлийн хүүний 1.8 нэгж хувь, банкны ашиг болон бусад зардал 12 хувь, зээлийн хүүний 1.9 нэгж хувийг тус тус эзэлж байна. Зээлийн хүүг бүрдүүлж байгаа дээрх хүчин зүйлсийн нөлөөллийг бууруулахад аливаа төрийн болон хувийн хэвшлийн үйл ажиллагаанаас үл хамаарч санхүү эдийн засаг, хууль эрх зүй зэрэг олон салбар байгууллагын оролцоог шаардах, чиг үүргийг уялдуулах, хамтын ажиллагааг



бүрдүүлсний үндсэн дээр шийдвэрлэгдэх асуудал юм.

Иймд дээрх нөхцөл байдал, өнгөрсөн хугацаанд төрөөс зээлийн хүүг бууруулахтай холбогдон гарч байсан бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүн, сул тал зэргийг судалсны үндсэн дээр макро болон микро түвшинд зээлийн эх үүсвэрийн өртгийг бууруулах, мөнгөний бодлогын хэрэгслийг уян хатан болгож эдийн засгийг дэмжих, санхүүжилтийн шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлж, цахимжуулах, эх үүсвэрийн төвлөрлийг бууруулах, зээлийн мэдээллийн ашиглалтыг нэмэгдүүлэх, зээл түүнтэй адилтгах хэлцлээс үүдэлтэй шаардах эрхийг баталгаажуулах, банкны зохистой засаглал, хяналтын тогтолцоог бэхжүүлэх, төрийн зохицуулах байгууллагын шимтгэл, хураамжийг бууруулах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Зээлийн хүүг бууруулах стратегийн хүрээнд зээлийн хүүг 2019 оны суурь

түвшнээс 4 нэгж хувиар бууруулж, 2023 оны эцэст 1 хувьд хүргэхээр хэрэгжилтийг хангаж ажиллахаар дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Зээлийн эх үүсвэрийн зардлыг бууруулах макро тогтвортой орчныг бүрдүүлэх;
2. Зээлийн эрсдэлийн зардлыг бууруулах;
3. Банкны үйл ажиллагааны зардлыг бууруулах;
4. Хөрөнгийн захыг хөгжүүлэх, өрсөлдөөнийг бий болгож санхүүжилтийн зардлыг бууруулах

Тогтоолын төслийг баталж, хэрэгжүүлснээр санхүүгийн эх үүсвэр нэмэгдэн, хүү буурах макро орчин бүрдэж, санхүүгийн зах зээлийн хөгжил, хууль эрх зүйн орчин, банкны эрсдэл даах чадвар, засаглал, үр ашигт байдал сайжирч, зээлдүүлэгчийн эрх баталгаажин, зээлийн гэрээнд заасан талуудын үүргийн гүйцэтгэл хангагдах суурь нөхцөл бүрдэх ач холбогдолтой.






## 4 ЭДИЙН ЗАСАГ ДАХЬ ӨӨРЧЛӨЛТҮҮД

- Төгрөгийн ам.доллартай харьцах ханш оны эхнээс **3.5%**, өмнөх оны мөн үеэс **6.9%**-иар сулраад байна /2020.08.13-ны байдлаар/.
- ТОП-20 индексийн үзүүлэлт **16,540** болж оны эхнээс 14.4%-иар буураад байгаа боловч сүүлийн 14 хоногийн хугацаанд харьцангуй тогтвортой байна /2020.08.13-ны байдлаар/.
- 2020 оны 07 дугаар сарын байдлаар гадаад худалдааны эргэлт **6,730.7 сая ам.доллар** гарч, тэнцэл **846.6 сая ам.долларын ашигтай** гарлаа /2020.07 сарын байдлаар/.
- Зөвхөн 7 дугаар сард 960.6 сая ам.долларын экспорт, 482.1 сая ам.долларын импорт хийсэн байна /2020.07 сарын байдлаар/.


### Гадаад худалдаа /2020.07/:

Зураг 1. Гадаад худалдааны жилийн өсөлт, сараар



Эх сурвалж: Гаалийн Ерөнхий Газар

Зураг 2. Экспорт, импорт, тухайн сараар



Эх сурвалж: Гаалийн Ерөнхий Газар

### Хөрөнгийн зах /2020.08.13/:

Зураг 3. МУ-ын бондын өгөөж (%)



Эх сурвалж: Монгол Улсын Хөрөнгийн Бирж

**5 МОНГОЛ УЛСЫН ЭКСПОРТЫН ГОЛ ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНИЙН ӨӨРЧЛӨЛТ**

	Бодит гүйцэтгэл						Товч тайлбар
	Үнэ (-1 day) 2020/08/21	Өөрчлөлт					
		daily	weekly	monthly	year to date	YoY	
<b>Зэс</b>	6511.5	0.3%	2.4%	1.6%	6.0%	16.4%	БНХАУ-ын үйлдвэрлэлийн салбарын идэвхжил хадгалагдаж, улс орнуудын хөл хорио суларч эхэлсэн, эрэлт нэмэгдсэн, нөөц буурсан нөлөөгөөр үнэ өмнөх долоо хоногийн түвшнээс нэмэгдэхэд нөлөөлөв.
<b>Коксжих нүүрс</b>	107.8	-	-	-	-	-39.5%	Худалдааны маргаан, КОВИД-19-ийн нөлөөгөөр эрэлт нэмж буурах төлөв болон БНХАУ-ын дотоодын үйлдвэрлэл нэмэгдэх нөлөөгөөр үнэ бага түвшинд хадгалагдаж байна.
<b>Төмрийн хүдэр</b>	125.3	0.0%	5.7%	15.7%	35.4%	42.6%	БНХАУ-ын гангийн үйлдвэрлэлийн сэргэлт үргэлжилсэн, боомтууд дээрх нөөц нэмэгдэж буй, хөл хорионы улмаас Бразилийн нийлүүлэлт буурахаар байгаа хэдий ч энэ нь богино хугацаанд шийдвэрлэгдэх хүлээлтийн нөлөөгөөр үнэ өмнөх долоо хоногоос нэмэгдэв.
<b>Алт</b>	1940.5	-0.6%	-0.8%	1.4%	26.2%	26.2%	Дэлхийн эдийн засгийн тодорхой бус байдал өндөр байгаа тул аюулгүй хөрөнгө оруулалтад тооцогддог алтны эрэлт өндөр байна.
<b>Газрын тос (Брент)</b>	44.3	1.8%	0.7%	4.1%	-32%	-23.9%	АНУ дахь нөөц хадгалагдсан, олон улсын эрчим хүчний агентлаг газрын тосны эрэлтийг 5-р сарын төсөөллөөс нэмэгдүүлсэн ч КОВИД-19-ийн тархалт нэмэгдсэн хэвээр, ОПЕК-ийн нэгдэл+ нийлүүлэлтээ танасан ч 8-р сараас эхлэн тус хэмжээг өдрийн 9.6 сая баррелиас 7.7 сая баррель болгосон нөлөөгөөр сулруулж эхлэх нөлөөгөөр үнийн өсөлт хадгалагдаж байна.